



# ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ\*

2019 оны 5 дугаар сар


**Ерөнхий тойм:** Энэ оны эхний 5 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 10%-иар буюу 514 сая ам.доллараар өсч 5,578 сая ам.доллар байв. Үүнд экспорт 13%-иар буюу 378 сая ам.доллараар, импорт 6%-иар буюу 136 сая ам.доллараар тус тус өссөн нь нөлөөлөв. Тайлант хугацаанд худалдааны тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 242 сая ам.доллараар өсч 948 сая ам.долларын ашигтай гарлаа.

Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/


Төрөл	Жилээр			Өөрчлөлт				Эхний 5 сар			Өөрчлөлт			
	2016	2017	2018	2017/2016		2018/2017		2017	2018	2019	2018/2017		2019/2018	
				Дүн	Хувь	Дүн	Хувь				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	8,274	10,536	12,887	2,262	27%	2,351	22%	4,016	5,064	5,578	1,048	26%	514	10%
Экспорт	4,916	6,201	7,012	1,284	26%	811	13%	2,519	2,885	3,263	367	15%	378	13%
Импорт	3,358	4,335	5,875	977	29%	1,540	36%	1,498	2,179	2,315	681	45%	136	6%
Тэнцэл	1,558	1,865	1,137	307		(728)	-39%	1,021	706	948	(314)	-31%	242	34%

**Валютын төлбөртэй худалдааны тэнцэл\*\*** 2019 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 199 сая ам.доллараар өсч 1,023 сая ам.долларын ашигтай гарсан байна.

Зураг 1. Валютын төлбөр (ВТ)-тэй худалдаа /3 сарын гулсах дундаж/



Зураг 2. Худалдааны тэнцэл, голлох түнш орнуудаар



**Хөрш орнуудтай хийсэн худалдааг** авч үзвэл, нийт бараа эргэлтийн 66% буюу 3,671 сая ам.долларын худалдааг БНХАУ-тай, 12% буюу 648 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийжээ. ОХУ-тай хийсэн худалдаа өмнөх оны мөн үеэс 1.6%-иар буурсан бол БНХАУ-тай хийсэн худалдаа 8%-иар өслөө.

Зураг 3. Худалдааны нөхцөлийн индекс /3 сарын гулсах дундаж/



**Гадаад худалдааны нөхцөлийн индекс** 2019 оны 5 дугаар сард өмнөх оны мөн үеэс 6%-иар, өмнөх сараас 1%-иар өсч 2.191-д хүрлээ. Худалдааны нөхцөл өмнөх сараас сайжирахад хөрөнгө оруулалтын импортын үнийн бууралт голлон нөлөөлөв.

\*Энэхүү тоймыг ГЕГ-ын "Гадаад худалдааны барааны статистик мэдээлэл"-д үндэслэн, дэлхийн улс орнуудын Төв банкны практикт нийцүүлж, судалгаа шинжилгээний ажлын хэрэгцээнд зориулан боловсруулав.

\*\* Нийт худалдааны дүнгээс дахин экспорт/импорт, боловсруулах бараа, бараа солилцоо, хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн бараа, гадаадын зээлийн хөрөнгөөр нийлүүлсэн бараа болон бусад барааг хассан дүн болно.

**Экспорт** 2019 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 13%-иар буюу 378 сая ам.доллараар өсөв. Үүнд уул уурхайн бүтээгдэхүүний экспорт өссөн нь нийт экспортыг 13 нэгж хувиар өсгөх чиглэлд нөлөөлөв. Уул уурхайн түүхий эдийн нийт экспортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 0.7 нэгж хувиар, мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортын эзлэх хувь 0.2 нэгж хувиар тус тус өссөн байна.

**Хүснэгт 2. Экспортын гүйцэтгэл /сая ам.доллар/**

Төрөл	2017			2018			2019			Δ (2018/2017)			Δ (2019/2018)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	% <sup>2</sup>	Дүн	Өсөлт	% <sup>2</sup>
<b>1. Уул уурхай</b>		<b>2,207</b>	<b>88%</b>		<b>2,571</b>	<b>89%</b>		<b>2,932</b>	<b>90%</b>	<b>364</b>	<b>16%</b>	<b>14%</b>	<b>361</b>	<b>14%</b>	<b>13%</b>
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	605	632	25%	601	823	29%	624	893	27%	191	30%	8%	70	8%	2%
1.2. Чулуун нүүрс	14,925	1,008	40%	14,114	1,104	38%	15,061	1,272	39%	96	10%	4%	168	15%	6%
1.3. Боловсруулаагүй нефть	3,090	154	6%	2,766	177	6%	2,628	150	5%	23	15%	7%	(27)	-15%	-7%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	2,176	136	5%	2,768	131	5%	3,489	207	6%	(5)	-4%	0%	76	58%	3%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	3,537	142	6%	3,432	144	5%	4,665	196	6%	3	2%	0%	51	36%	2%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	48	72	3%	52	93	3%	65	96	3%	20	28%	7%	3	3%	0%
1.7. Жонош, лейцит, нефелинт	112	26	1%	153	51	2%	221	75	2%	24	93%	7%	24	48%	7%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	3	14	1%	2	18	1%	2	20	1%	5	33%	0%	2	11%	0%
1.9. Гянтболдын хүдэр, баяжмал	0	1	0%	0	2	0%	0	2	0%	0	34%	0%	0	0%	0%
1.10. Мөнгө /тонн/	0	0	0%	0	0	0%	0	-	0%	0	0%	0%	(0)	0%	0%
1.11. Бусад	170	22	1%	211	27	1%	75	21	1%	6	26%	0%	(6)	-23%	0%
<b>2. Мал аж, ахуй</b>	<b>173</b>	<b>168</b>	<b>7%</b>	<b>209</b>	<b>191</b>	<b>7%</b>	<b>184</b>	<b>224</b>	<b>7%</b>	<b>22</b>	<b>13%</b>	<b>1%</b>	<b>33</b>	<b>17%</b>	<b>1%</b>
2.1. Амьд мал, малын мах	5	8	0%	9	20	1%	11	21	1%	13	162%	0%	0	1%	0%
2.2. Арьс, шир	160	14	1%	191	11	0%	161	8	0%	(3)	-24%	0%	(2)	-23%	0%
2.3. Малын өлөн гэдэс	0	3	0%	0	3	0%	0	4	0%	0	11%	0%	1	0%	0%
2.4. Ноолуур	4	138	5%	5	151	5%	5	181	6%	13	10%	7%	30	20%	7%
2.5. Ноос, бусад үс, хялгас	3	5	0%	3	5	0%	5	9	0%	(0)	-3%	0%	4	79%	0%
2.6. Бусад	1	1	0%	0	1	0%	2	1	0%	(0)	-12%	0%	(0)	-20%	0%
<b>3. Газар тариалан</b>	<b>61</b>	<b>4</b>	<b>0%</b>	<b>6</b>	<b>2</b>	<b>0%</b>	<b>22</b>	<b>5</b>	<b>0%</b>	<b>(2)</b>	<b>-55%</b>	<b>0%</b>	<b>4</b>	<b>205%</b>	<b>0%</b>
<b>4. Аж үйлдвэрлэл</b>	<b>222</b>	<b>139</b>	<b>6%</b>	<b>132</b>	<b>121</b>	<b>4%</b>	<b>195</b>	<b>102</b>	<b>3%</b>	<b>(17)</b>	<b>-12%</b>	<b>-1%</b>	<b>(19)</b>	<b>-16%</b>	<b>-1%</b>
4.1. Хүнс	11	49	2%	10	30	1%	11	27	1%	(19)	-38%	-7%	(3)	-11%	0%
4.2. Ноолууран адал	0	5	0%	0	7	0%	0	11	0%	2	38%	0%	4	60%	0%
4.3. Бусад хувцас, пүтэл, адал	0	4	0%	1	5	0%	1	4	0%	0	11%	0%	(1)	-11%	0%
4.4. Уул уурхай	15	44	2%	15	46	2%	51	42	1%	2	4%	0%	(3)	-7%	0%
4.5. Цахилгаан, электрон бараа	0	0	0%	0	0	0%	0	0	0%	(0)	-19%	0%	0	15%	0%
4.6. Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	1	33	1%	1	31	1%	1	14	0%	(2)	-6%	0%	(17)	-54%	-7%
4.7. Бусад	195	3	0%	104	2	0%	131	3	0%	(0)	-11%	0%	1	33%	0%
<b>5. Бусад</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>0%</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0%</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0%</b>	<b>(0)</b>	<b>-8%</b>	<b>0%</b>	<b>(0)</b>	<b>-6%</b>	<b>0%</b>
<b>Нийт дүн</b>	<b>2,519</b>	<b>2,519</b>		<b>2,885</b>	<b>2,885</b>		<b>3,263</b>	<b>3,263</b>		<b>367</b>	<b>15%</b>		<b>378</b>	<b>13%</b>	

%<sup>2</sup> - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

**Хүснэгт 3. Экспортын өөрчлөлт, 2019 оны эхний 5 сар**

Төрөл	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо	%	Үнийн	%	Нийт	%
<b>1. Уул уурхай</b>	<b>204</b>		<b>157</b>		<b>361</b>	<b>14%</b>
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	33	48%	36	52%	70	8%
1.2. Чулуун нүүрс	80	48%	88	52%	168	15%
1.3. Боловсруулаагүй нефть	(8)	29%	(19)	71%	(27)	-15%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	43	33	76	58%	76	58%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	52	101%	(0)	-1%	51	36%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	19	610%	(16)	-510%	3	3%
1.7. Жонош, лейцит, нефелинт	23	95%	1	5%	24	48%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	0	3%	2	97%	2	11%
1.11. Бусад	(38)	616%	32	-516%	(6)	-23%
<b>2. Мал аж, ахуй</b>	<b>(12)</b>		<b>45</b>		<b>33</b>	<b>17%</b>
2.1. Амьд мал, малын мах	3	1068%	(3)	-968%	0	1%
2.2. Арьс, шир	(2)	63%	(1)	37%	(2)	-23%
2.3. Малын өлөн гэдэс	0	41%	1	59%	1	0%
2.4. Ноолуур	(18)	-58%	48	158%	30	20%
<b>3. Газар тариалан</b>	<b>4</b>		<b>(0)</b>		<b>4</b>	<b>205%</b>
<b>4. Аж үйлдвэрлэл</b>	<b>15</b>		<b>(34)</b>		<b>(19)</b>	<b>-16%</b>
<b>5. Бусад</b>	<b>0</b>		<b>(0)</b>		<b>(0)</b>	<b>-6%</b>
<b>Нийт дүн</b>	<b>211</b>		<b>168</b>		<b>378</b>	<b>13%</b>

\* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

**Зураг 4. Дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ**



2019 оны эхний 5 сард экспортын гадаад худалдааны тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 211 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 168 сая ам.доллараар тус тус өслөө. Чулуун нүүрс, зэсийн баяжмалын экспортын биет хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 113 сая ам.доллараар, үнийн өсөлтөөс шалтгаалж 124 сая ам.доллараар өсөв. Аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспортын биет хэмжээ өссөнөөс шалтгаалж 15 сая ам.доллараар өссөн боловч үнийн өөрчлөлтөөс шалтгаалан 34 сая ам.доллараар буурсан байна.

Дэлхийн зах зээл дээрх 1 унц алтны дундаж үнэ 2019 оны 5 дугаар сард 1,284 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 1.5%-иар, өмнөх сараас 0.1%-иар буурсан байна. “А” зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн дундаж үнэ тайлант сард харгалзан 6,018; 100 ам.долларт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад зэс 12%-иар буурсан бол төмрийн хүдэр 51%-иар өссөн, өнгөрсөн сараас зэсийн үнэ 7%-иар буурсан бол төмрийн хүдэр 6%-иар өссөн. Чулуун нүүрсний экспортын хилийн үнэ 5 дугаар сард 84 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 7%-иар өссөн хэдий ч өмнөх сараас 3%-иар буурлаа.

**Импорт** 2019 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 6%-иар буюу 136 сая ам.доллараар өсөв. Импортын 6 нэгж хувийн өсөлтийг ерөнхий ангиллаар задалж үзвэл хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний өсөлт 4 нэгж хувийг, хэрэглээний бүтээгдэхүүний өсөлт 3 нэгж хувийг, нефтийн бүтээгдэхүүний өсөлт 2 нэгж хувийг бүрдүүлж байна.

**Хүснэгт 4.** Импортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2017			2018			2019			Δ (2018/2017)			Δ (2019/2018)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	% <sup>2</sup>	Дүн	Өсөлт	% <sup>2</sup>
<b>Хэрэглээний бүтээгдэхүүн</b>		<b>471</b>	<b>31%</b>		<b>591</b>	<b>27%</b>		<b>652</b>	<b>28%</b>	<b>119</b>	<b>25%</b>	<b>8%</b>	<b>62</b>	<b>10%</b>	<b>3%</b>
Түргэн эдэлгээтэй	346	266	18%	375	318	15%	340	326	14%	51	19%	3%	8	2%	0%
Хүнс	138	184	12%	175	221	10%	163	231	10%	37	20%	2%	9	4%	0%
Эм, тариа	1	34	2%	1	42	2%	1	40	2%	8	23%	1%	(2)	-5%	0%
Бусад түргэн эдэлгээтэй бараа	207	48	3%	199	54	3%	176	55	2%	6	13%	0%	0	1%	0%
Удаан эдэлгээтэй	86	205	14%	74	273	13%	139	327	14%	68	33%	5%	54	20%	2%
Гутал, хувцас, цүнх	25	22	1%	23	29	1%	29	27	1%	7	30%	0%	(2)	-7%	0%
Гэр ахуйн цах.хэрэгсэл ба тавилга	35	34	2%	22	43	2%	79	42	2%	9	26%	1%	(1)	-2%	0%
Авто машин, түүний салбэр хэрэгсэл	1	122	8%	1	171	8%	1	223	10%	49	40%	3%	52	30%	2%
Бусад удаан эдэлгээтэй бараа	26	27	2%	28	31	1%	29	35	2%	4	15%	0%	4	15%	0%
<b>Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн</b>	<b>436</b>	<b>547</b>	<b>37%</b>	<b>678</b>	<b>896</b>	<b>41%</b>	<b>523</b>	<b>977</b>	<b>42%</b>	<b>349</b>	<b>64%</b>	<b>23%</b>	<b>81</b>	<b>9%</b>	<b>4%</b>
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	10	367	25%	10	570	26%	12	671	29%	203	55%	14%	101	18%	5%
Суудлаас бусад тээврийн хэрэгсэл, эд анги	0	86	6%	1	193	9%	1	237	10%	107	124%	7%	44	23%	2%
Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	9	281	19%	10	377	17%	11	434	19%	96	34%	6%	57	15%	3%
Барилгын материал	180	120	8%	264	238	11%	345	238	10%	118	98%	8%	0	0%	0%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	20	60	4%	18	88	4%	10	67	3%	28	47%	2%	(20)	-23%	-1%
<b>Аж үйлдвэрлэлийн орц</b>	<b>475</b>	<b>197</b>	<b>13%</b>	<b>578</b>	<b>303</b>	<b>14%</b>	<b>680</b>	<b>258</b>	<b>11%</b>	<b>106</b>	<b>54%</b>	<b>7%</b>	<b>(45)</b>	<b>-15%</b>	<b>-2%</b>
Хүнсний орц	17	8	1%	232	62	3%	16	9	0%	54	674%	4%	(53)	-86%	-2%
Химийн бүтээгдэхүүн	66	39	3%	81	49	2%	80	45	2%	10	25%	1%	(4)	-7%	0%
Даавуу, утас, арьс, савжин эдлэл	17	8	1%	26	11	1%	34	12	1%	3	32%	0%	1	10%	0%
Цахилгаан эрчим хүч	1	54	4%	1	59	3%	1	59	3%	5	9%	0%	(1)	-1%	0%
Металлын хүдэр, баяжмал болон хаягдал	1	0	0%	0	0	0%	0	0	0%	0	19%	0%	0	58%	0%
Бусад аж үйлдвэрлэлийн зориулалтай	334	87	6%	337	122	6%	391	133	6%	35	40%	2%	11	9%	0%
<b>Нефтийн бүтээгдэхүүн</b>	<b>475</b>	<b>279</b>	<b>19%</b>	<b>578</b>	<b>386</b>	<b>18%</b>	<b>680</b>	<b>426</b>	<b>18%</b>	<b>106</b>	<b>38%</b>	<b>7%</b>	<b>40</b>	<b>10%</b>	<b>2%</b>
Дизель түлш	268	144	10%	322	207	9%	406	253	11%	63	43%	4%	46	22%	2%
АИ-92, АИ-95	145	88	6%	130	88	4%	191	111	5%	0	1%	0%	22	25%	1%
А-80 болон бусад	62	47	3%	125	90	4%	83	62	3%	43	91%	3%	(28)	-31%	-1%
<b>Бусад</b>	<b>7</b>	<b>3</b>	<b>0%</b>	<b>11</b>	<b>4</b>	<b>0%</b>	<b>56</b>	<b>2</b>	<b>0%</b>	<b>1</b>	<b>32%</b>	<b>0%</b>	<b>(1)</b>	<b>-36%</b>	<b>0%</b>
<b>Нийт дүн</b>		<b>1,498</b>		<b>2,179</b>			<b>2,315</b>			<b>681</b>	<b>45%</b>		<b>136</b>	<b>6%</b>	

<sup>2</sup> - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

**Хүснэгт 5.** Импортын өөрчлөлт, 2019 он эхний 5 сар

Төрөл*	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо	%	Үнийн	%	Нийт	%
Хэрэглээний бүтээгдэхүүн	42	69%	19	31%	62	10%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	204	252%	(123)	-152%	81	9%
Аж үйлдвэрлэлийн орц	(92)		47		(45)	-15%
Нефтийн бүтээгдэхүүн	56	140%	(16)	-40%	40	10%
Дизель түлш	52	113%	(6)	-13%	46	22%
АИ-92, АИ-95	35	157%	(13)	-57%	22	25%
А-80 болон бусад	(31)	10%	3	-10%	(28)	-31%
Бусад	2		(3)		(1)	-36%
<b>Нийт дүн</b>	<b>212</b>	<b>156%</b>	<b>(76)</b>	<b>-56%</b>	<b>136</b>	<b>6%</b>

\* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

**Зураг 5.** Импортын бүтээгдэхүүний жилийн өсөлт /3 сарын гулсах дундаж/



2019 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 81 сая ам.доллараар, хэрэглээний бүтээгдэхүүний импорт 62 сая ам.доллараар, нефтийн бүтээгдэхүүний импорт 40 сая ам.доллараар тус тус өссөн бол аж үйлдвэрлэлийн орц бүтээгдэхүүний импорт 45 сая ам.доллараар буурснаар нийт импорт 136 сая ам.доллараар өслөө.

Нефтийн бүтээгдэхүүний импортын хилийн үнэ 2019 оны 5 дугаар сард өмнөх оны мөн үеэс 1 хувиар буурсан боловч өмнөх сараас 3 хувиар өсч тонн тутамд 668 ам.долларт хүрэв.